

## Marco Pires – Supplier Forum Speech

Та бүхэнд баярлалаа.

“Оюу толгой” болон гүний уурхайн төслийг төлөөлөн өнөөдөр энэхүү тайзнаас та бүхэнтэй мэндчилж байгаадаа сэтгэгдэл нэн өндөр байна.

Оюу толгойд дэлхийн түвшний нөөц баялаг байна. Үүн дээр суурилж манай хамт олон дэлхийн жишигт хүрсэн үндэсний компанийг бүтээн босгосон билээ.

“Хамт олон” гэж би зөвхөн Оюу толгойн ажилтнуудыг хэлээгүй.

“Хамт олон” гэдэгт бидэнтэй хамтран ажилладаг ханган нийлүүлэгч байгууллагууд, гэрээт компаниуд цөм орж байгаа юм.

Бид гүний уурхайн төслийг хугацаанд нь, төсөвтөө багтаан, хамгийн чухал нь аюул осолгүйгээр гүйцэтгэхээр шамдан ажиллаж байна.

Гүний уурхай нь Оюу толгойн нийт баялгийн 80 хувийг нээгээд зогсохгүй, уурхайг дэлхийн хамгийн өрсөлдөх чадвар өндөр, урт хугацааны, зах зээлд үлэмж нөлөөтэй зэс үйлдвэрлэгчдийн нэг болгох юм.

“Оюу толгой”-н үйлдвэрлэл, үйл ажиллагаа эхлээд удаагүй байгаа боловч энэ уурхай нь ирэх олон арван жилийн түрш үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсад бодит үр өгөөж бий болгосоор байх юм.

Тиймээс бидний өнөөдөр гаргаж байгаа шийдвэрүүд ирээдүйд нөлөөтэй гэдгийг бид ухамсарлан ажилладаг.

Өнөөдрийн арга хэмжээний үеэр та бүхэн манай ханган нийлүүлэлтийн багийнхантай харилцан ярилцаж, бидний хэрэгцээ шаардлагын тухай ойлгож авах үеэр “уурхайн амьдрал” гэсэн үгийг олонтаа сонсох байх.

“Уурхайн амьдрал” гэж юу гэсэн үг болох талаар товч тайлбарлая.

Ямар ч төслийн барилга бүтээн байгуулалтын үе шат нь төлөвлөгөө, хуваариас ихээхэн хамаардаг.

Барилга, бүтээн байгуулалтын үе шатанд үлэмж тоног төхөөрөмж болон техникийн буюу нарийн мэргэжлийн үйлчилгээг нэг удаадаа ашиглах шаардлага гардаг. Үүний жишээнд бутлуур, туузан дамжуулга зэрэг материалын тээвэрлэлтийн систем орно. Ийм нэг удаагийн үйлчилгээ нь тухайн үйл ажиллагаа явуулж буй дотоодын зах зээлд тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэх шинэ бизнес, техникийн үр чадварыг бий болгох боломжийг хязгаарладаг.

Барилга бүтээн байгуулалтын үе шатны дараа тухайн төслийн өргөжих, эрчимжих үе шат ирдэг. Энэ үеэр бараа, бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ихэсч, үйл ажиллагааны чиглэл үр чадвартай, зардал багатай, дотоодын ханган нийлүүлэлтэд ирдэг. Энэ хэрэгцээ шаардлага нь төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ болон бусад хэсгүүдэд гардаг юм.

Үүний дараа үйл ажиллагааны үе шат ирдэг. Энэ үе шатанд төслийн эрэлт урьдаас тооцолж болохуйц, илүү тогтвортой болдог бөгөөд үйл ажиллагааны үр ашгийг сайжруулахад тасралтгүй анхааран ажилладаг. Ингэснээр техник, технологи болон үр чадварын шилжилт өрнөж, дотоодоос нийлүүлэх бараа үйлчилгээ рүү шилждэг. Энэ нь дотоодоос орж ирж буй үнэ цэн, үр өгөөжийг нэмэгдүүлдэг.

Харин “Оюу толгой”-н гүний уурхайн төсөл нь өөрийн гэсэн онцлогтой. Учир нь, төслийг хэрэгжүүлэхэд нэг удаагийн тоног төхөөрөмжийг авч суурилуулах шаардлагатайн дээр одоогоос 2022 он хүртэлх хугацаанд 50 км орчим хөндлөн нэвтрэлтийг гүйцэтгэх төлөвлөгөөтэй.

Гүний уурхайн төсөлд одоогоор тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажил хэрэгжихийн зэрэгцээ уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа.

Энэ нь гүний уурхайн төслийн хувьд хөндлөн нэвтрэлтээ хийж байгаа учраас төслийн үйл ажиллагааны шатанд бий болдог боломжууд одоо бий болоод эхэлчихсэн гэсэн үг юм.

Өөрөөр хэлбэл, гүний уурхайн малталтын ажил үргэлжлэн эрчимшиж буй энэ үед үйл ажиллагааны шатанд шаардагддаг бараа, үйлчилгээний эрэлт аль хэдийнэ эхэлчихсэн байгаа. Гүний уурхайн төслийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай бэхэлгээ, бетон зуурмаг, агааржуулалтын түүз, өндөр нягттай полиэтилен шугам хоолой, насос зэрэг олон бүтээгдэхүүнийг бид зах зээлээс хайгаад эхэлчихсэн байна.

“Оюу толгой” нь үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулж эхлээд удаагүй байгаа ч дотоодын худалдан авалт, ханган нийлүүлэлтийн чиглэлээр дэлхийн бусад төсөөтэй уурхайнуудаас илүү өндөр гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Ил уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны шатуудад “Оюу толгой” нь дотоодын ханган нийлүүлэгчидтэй ажиллаж ирсэн бөгөөд одоо дотоодын худалдан авалтын шинэ боломжуудад анхааран ажиллаж байна.

Бүтээн байгуулалтын үе шатанд техник, технологи, үр чадвар бий болгох боломж хязгаарлагдмал байдаг хэдий ч бид анхнаасаа уурхайн амьдралд шаардлагатай бараа үйлчилгээнүүдэд анхааран ажиллаж, ханган нийлүүлэгчид та бүхэнтэй хамтран ажиллах боломжийг өргөжүүлэхээр ажилласаар ирсэн юм.

Бид ханган нийлүүлэлтийнхээ сүлжээнд дотоодын бараа үйлчилгээг байж болох хамгийн дээд түвшинд байлгаж, үйлдвэрлэл, үйлчилгээнд үнэ цэн нэмэгдүүлэхэд голлон анхаарч байгааг та бүхэн өнөөдрийн арга хэмжээнээс анзаарах байх.

Бид та бүхэнтэй болон бусад оролцогч талуудтайгаа хамтран ажиллаж, манай ханган нийлүүлэлтийн эрэлт, баримтлах зарчмуудын тухай бүрэн ойлголтыг өгч, тогтвортой бизнесийг бий болгохыг дэмжин ажиллана.

Нэг жилийн өмнө бид ийм форум зохион байгуулж, гүний уурхайн төслийг та бүхэнд танилцуулж байсан билээ.

Өнөөдрийн арга хэмжээгээр дамжуулан бид Монгол Улсын хөгжил дэвшилд урт хугацаанд хувь нэмэр оруулах урт замдаа хамтдаа дахин нэг том алхам хийж байна.

Баярлалаа.